



ГОВЬСУМБЭР АЙМАГ ДАХЬ УУЛ УУРХАЙН ЖИШИГ СУРГУУЛЬ
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ

*Сэдэв: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН БАГШ НАРЫН
ТАНХИМЫН БУС ЦАГИЙГ ТООЦОХ НЬ БАГШИЙН ХӨГЖИЛД
НӨЛӨӨЛӨХ НЬ*

Химиин багш М. Дэлгэрням
Боловсролын тэргүүний ажилтан, магистр, ахлах багш

Чойр хот

2018 он

Товьёог

1. Оршил

- Зорилго
- Зорилт
- Үндэслэл
- Судалгааны аргууд

2. Нэгдүгээр бүлэг

- Онолын хэсэг- Багшийн хөгжил-багц цаг тооцох журам, аргачлал
- Нэр томъёоны тайлбар

3. Хоёрдугаар бүлэг

- Судалгааны хэсэг
- Судалгааны дүгнэлтүүд

4. Дүгнэлт

- Илтгэлийн дүгнэлт
- Шинэ санаа, санаачлага

5. Ном зүй

6. Хавсралт

Оршил

Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын гаргасан 2013 оны 09 сарын 13 ны өдөр А/198//215 дугаар тушаал “Мэргэжлийн боловсрол сургалтын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам” ыг хэрэгжүүлээд 5 жил болж байна. Энэ журмыг манай сургуулийн багш нар хэрэгжүүлээд тухайн журмын дагуу багш нарын багц цагийг тооцоход дахин өөрчлөх шаардлага байгаа гэдгийг өнгөрсөн жилүүдэд багшийн ажлыг үнэлэх, багц цаг тооцож буй байдлаас харагдаж байгааг 2017 оны 11 сарын 02 нд багш М.Дэлгэрням Ж.Норжмаа, М.Баярмаа нарын багц цаг тооцох журмын хэрэгжилтийг сайжруулах тооцох аргачлалыг боловсронгуй болгох зорилгоор зохион байгуулсан хэлэлцүүлэгээс гарсан багш нарын санал, зөвлөмжөөс харж болно.

/Хавсралт 1/

Үндэслэл: Мэргэжлийн боловсролын багш нарын сургалтын ажлыг дээрх журмын дагуу үнэлж тооцож буй байдал нь багшийн ажлыг үнэлэх, өөрийн хөгжих, нөхцөл боломжийг хангаж чадаж байгаа эсэхэд дүгнэлт гаргахад хүргэлээ.

Зорилго: “Мэргэжлийн боловсролын сургуулийн багшийн сургалтын цагийг багц цагаар тооцох журам”-ын хэрэгжилт, тооцох аргачлал нь багшийн ажлыг үнэлэх дүгнэх, өөрийгөө хөгжүүлэхэд хэрхэн нөлөөлж буйг судлан дүгнэлт гаргах

Зорилт:

- МБС-ын багш нарын багц тооцох журам, түүний хэрэгжилтэнд сургуулийнхаа хэмжээнд дүгнэлт гаргах
- МБС-ын багш нарын багц цагийг тооцох журам нь багшийн хөгжилд хэрхэн нөлөөлж буйд судалгаа хийн дүгнэлт гаргах
- Судалгааны үндсэн дээр дүгнэлт гарган “Багшийн хөгжил” дэвтэр, Ажил үүргийн календарийн ашиглалт, ач холбогдол /Хавсралт 2,3/

Судалгааны арга

- Мэдээлэл түүвэрлэх, эх сурвалжийн анализийн аргыг сэдвийн судлагдсан байдлыг тогтоож онолын хэсгийг боловсруулах
- Хэлэлцүүлэгийн аргыг багш сургалтын цагийг багц цагаар тооцоход тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замуудыг тодорхойлох
- Ажиглалтын аргыг багш нарын хөгжлийн явцыг мэдэх
- Статистик боловсруулалтын аргыг цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийхэд тус тус хэрэглэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ : ОНОЛЫН ХЭСЭГ

1. Багшийн ажлыг үүргийг дараах байдлаар ангилж үздэг байна.

А. Багшийн үндсэн ажил- ажлын байрны тодорхойлолтонд тусгасан ажил үүрэг

Б. Багшийн нэмэлт ажил- Багшийн ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй ажил, үйлчилгээ

В. Нэмэгдэл ажил - Багшийн ажлын байрны тодорхойлолтод шууд хамаарахгүй, засгийн газрын тогтоолоор зөвшөөрөгдсөн ажлууд ордог байна.

МБС-ын багш нарын ажил үүрэгт 11 үүрэг 91 ажилбартай, алхамтай бүхий ажил үүрэг гүйцэтгэдэг гэсэн судалгааг гаргасан байна. Үүнд. ^{ЧЧС}Өөрийгөө хөгжүүлэх үүрэгт хамгийн олон буюу нийт ажилбарын 20 хувийг эзэлж байгаа боловч дээрх үүрэг ажилбариуд нь бүхэлдээ багтаж байна. Нийт алхам байна гэж ажлын хэсгээс томьёолсон байна.

Өөрийгөө хөгжүүлэх

- 1.1 Багшийн ёс зүйг хөгжүүлэх
- 1.2 Хууль эрх зүйн мэдлэгээ ахиулах
- 1.3 Сэтгэл судалын мэдлэгээ ахиулах
- 1.4 Заах арга зүйгээ сайржуулах
- 1.5 Баримт бичиг боловсруулах
- 1.6 ЧСС-ын онол арга зүйгээ сайжруулах
- 1.7 Сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах арга зүйгээ дээшлүүлэх
- 1.8 Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдах
- 1.9 Мэдээллийн технологийн ур чадварыг ахиулах
- 1.10 Гадаад хэлний мэдлэгээ ахиулах


- 1.11 Харилцааны ур чадварыг хөгжүүлэх
- 1.12 Багаар ажиллах чадварыг хөгжүүлэх
- 1.13 Шинэ техник технологид суралцах
- 1.14 Судалгааны арга зүйд суралцах
- 1.15 Зэргийг ахиулах
- 1.16 Уралдаанд бэлтгэх
- 1.17 Гадаад дотоодод туршлага судлах зэрэг ажил үүргийг тусгажээ.

Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын гаргасан 2013 оны 09 сарын 13 ны өдөр А/198//215 дугаар тушаал “Мэргэжлийн боловсрол сургалтын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам” нь 5 бүлэгтэй, 1 хавсралттай, зөвлөмж бүхий журамд зааснаар /Хавсралт 1ийн 5-13 хуудас/

- 1.1 Багшийн ажил нь Боловсролын тухай хууль, Мэргэжлийн болодвсрол, сургалтын тухай хуульдаасан багшийн үүргийн хүрээнд багшийн ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлогдох бөгөөд багц цаг нь сургалтын цагийн жилийн ачаалал, цалин нэмэгдэл хөлс тооцох үндэслэл болно.
- 2.1 Багшийн сургалтын цагийг танхимын ба танхимын бус цагаас бүрдэнэ.
- 2.2 Танхимын сургалтын цагт онол /лекц, семинари/ лабоатори, сургууль дээрх дадлагын , үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагыг хамруулна.
- 2.5 Нэг багц цагийн үнэлгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувиас доошгүй байна .
- 1.8 Багшийн жилийн цагийн ачаалал 20 кредит байна .
- 3.1 Онол, лаборатори, сургууль дээрх дадлагын 45 цагийг 1 багц цаг , үйлдвэрлэлийн болон төгсөлтийн өмнөх дадлагын болон танхимын бус сургалтын 72 цагийг 1 багц цаг гэж тооцно.
- 4.1 Багшийн албан тушаалын зэрэглэлээс хамааран багшийн цагийн ачааллыг дараах байдлаар нормчилж өгсөн.

Багшийн албан тушаал	Танхимын	Танхимын бус	Нийт / багц цаг/
Дадлагажигч	18	2	20
Багш	17	3	20
Ахлах	16	4	20
Зөвлөх	15	5	20

3. Багш хөгжих хамгийн гол хүчин зүйл бол сонирхол, хүсэл, тэмүүлэл сурх таатай боломж, орчин юм. Хөгжсөн багш хамт олон нийгэмд шинэ мэдлэг, шинэ хандлага, итгэл үнэмшил, үнэт зүйлийг бий болгож байдаг.



Багшлах хөдөлмөр бол мэргэжлийн болон бусад хамт олныхоо дотор, ажлын байрандаа багш нар өөрсдөө мэдлэг эзэмшиж, туршлагажиж байхын зэрэгцээ өдөр тутмынхаа үйл ажиллагаандаа дун шинжилгээ хийн алдаагаа засах явцдаа хөгждөг. Багш дан ганцаараа өөрөө бие даан мэдлэг боловсролоо дээшлүүлэн хөгжинө гэдэг бол өрөөсгөл ойлголт юм. Иймд багш хамт олон дотроо, хамтран ажиллах арга туршлагаа хуваалцах, хамтран хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах нь чухал ба сургуульд багш нарын бүтээлч хамтлаг байгуулан ажиллах нь багш хөгжихөд чухал байр суурь эзэлдэг учир одоогийн байгаа багийн бүтэц, үйл ажиллагаа нь багшийн багаар хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж ажилладаггүй.

Багш өөрийгөө хөгжүүлэхэд үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандаж, бүтээлчээр сэтгэж чадвал практик үйл ажиллагаанд ахиц өөрчлөлт гарч, мэргэжлийн хувьд өснө. Багш нар мэргэжлийн хувьд хөгжихийн тулд ажлын байран дээрээ бүтээлч санаачлага гарган эргэцүүлж, хөгжих боломжуудыг өөртөө нээж байх нь их чухал бөгөөд түүний нэг алхам нь өөрийн практик үйл ажиллагааг сайжруулах чухал хэрэглүүрийн нэг нь багшлах явцын тэмдэглэл хөтлөх явдал юм. Багшлах явцын тэмдэглэл хөтлөх нэг үндэслэл нь багшийн мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө байдаг. Мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөөг практик үйл ажиллагаа, өөрийн эрэлтэнд үндэслэн гаргах нь багшийн хөгжих үйл явцын эхлэл гэж хэлж болно.

Иймд багш Б.Туяа, М.Сандагсүрэн нартай хамтран “Багшийн хөгжил” дэвтэр, “Ажил үүргийн календарь”ийг багш нарт өдөр тутмын болон хийсэн ажлаа тэмдэглэх, нотолгоожуулах зориулалт бүхий дэвтэрийг гаргаж ашиглаж байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. Манай сургуулийн багш нар хөгжсөн үү? гэдгийг тоон үзүүлэлтээр авбал

График 1

2015 оны байдлаар багш нарын ур чадварын ангилалаар




График 2

2018 оны байдлаар






График 3



Мэргэжлийн зэргээр авч үзэхэд

График 4

2018 оны байдлаар



2. 2016-2017 оны хичээлийн жилийн танхимын бус цагийг тооцсон байдалд хийсэн судалгаа

/ Судалгааг багш Ж.Норжмаа, М.Баярмаа нартай хамтран хийсэн/


2017оны 11сарын 02 нд багш нарын дунд Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн сургалтын багц цагаар тооцох журам"-ын хэрэгжилт, сайжруулах сургалт хэлэлцүүлэгийг зохион байгуулсан ба тус ажлын хүрээнд

- ✓ Удирдамж боловсруулан батлуулах
- ✓ Судалгаа авах
- ✓ Бусад сургуулиас судалгаа авах
- ✓ Зохион байгуулах
- ✓ Журмыг тооцох аргачлалыг шинэчлэн өөрчлөн үндэслэлийг бичиж багш нарын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн
- ✓ Санал зөвлөмж гаргасан.
- ✓ Захирлын зөвлөлд танилцуулсан .
- ✓ МБГ-ын мэргэжилтэн, Бүсийн аргазүйн төвийн менежер О.Саруул файлаар явуулсан .

Багш нарын цагийн ачаалал, ажлын байрны тодорхойлолтонд заасан ажил үүргийг багтаасан танхимын бус цагийн тооцох журамд 33 ажилбар байгааг 2016-2017 оны хичээлийн жилд нийт 35 багш цуглуулсан кредитийг доорх графикт


үзүүлсэн ба хамгийн өндөр буюу 13,72 кредит нь 987,8 цаг ногдож байгаа бөгөөд гүйцэтгэвэл зохих 3 кредитийг хасахад 10,72 кредит буюу 770,4 цаг илүү ажилласан буюу 1669200 төгрөгийн нэмэгдэл хөлс авсан байна

График 5



- Нийт 35 багшийн 9 сар цуглуулсан кредит нь 236,52 кредит бөгөөд 35 багшийн цуглуулбал зохих 107 кредитийг хасахад 129,52 кредит буюу 21370800 төгрөгийн нэмэгдэл хөлс авсан байлаа.
- Үүнийг 9 сардаа хувааж үзвэл, 1 багш дунджаар сард 0,75 кредит цаг гэж тооцуулах боломжтой ба дундаж кредит 6,75 кредит байна.

График 6



Дээрх графикаас харахад

- ✓ Багш нарын 11 хувь нь үндсэндээ цуглуулбал зохих кредитээ цуглуулаагүй буюу үндсэн ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн идэвхгүй, санаачлагагүй нэг хэсэг
- ✓ Багш нарын 49 хувь дундаж 3-7 кредит цуглуулсан байна. Энэ хэсэг хийх ёстой үүргэг даалгавараа биелүүлээд зарим нэг хүний ажилд оролцоод явдаг
- ✓ Багш нарын 40 хувь нь ажил үүргээ сайн гүйцэтгэдэг, санаачлагатай, идэвхтэй, манлайлагч нарын хэсэг гэж дүгнэж болно.

График 7



Багш нараас танхимын бус цагийг тооцох ажилбарууд таны хөгжилд нөлөөлдөг үү гэсэн асуултанд 82 хувь нь нөлөөлдөг, 9 % нь заримдаа, 9 % нь нөөлөлдөггүй гэсэн байна.

График 8-аас харахад багш нь хөтөлбөр хийх, сургалтын хэрэглэгдэхүүн шинээр хийх цахим хичээл хийх, гарын авлага хийх, илтгэл бичих, ур чадвар заах аргач багшийн уралдаан зэрэг тэмцээн уралдаанд оролцоход өөрийгөө хөгжүүлдэг гэсэн дүгнэлт гарсан байна.


Нөгөө талаас багц цагаа тооцуулахын тулд ач холбогдолгүй, үр дүн муутай, цаг үрсэн, олон ажил хийдэг нь өөрийгөө хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлдэггүй гэсэн байлаа.

Мөн тооцож буй албан тушаалтан шударга бодитой, ажлыг үр дүн ач холбогдлын зэргээс нь хамаарч үнэлдэггүй журмынхаа оноонд баригдан учир багш нарын ажил хийх урам зориг, хүсэл тэмүүллийг багасдаг сөрөг уу тал байдаг тухай

Y33k Gāṇha.

!paefnk-9 nnt y33exA xamrnnn olooh baru xamparAcah y33ylj3rtt dyoyd baru happhi
xamrnin nx xnnicah askntigap hb 4HC xeterngep Gonobcphytax Gancach hb erhepcch
xnh33nnn knntA baru hap eepnnh 3aaAar xnh33nnn xeterngepnr canh xnnicah Ga
cypryyjnnh xamk33AhA baru hapac cyAatrra abraxAh hntt baru 72 h3rknny
xeterngep xnnicah Ga har xeterngep xnnicah A ! kpeAvt erAvt Gancach hb heueucch rak


Baru hap A33px y3yyjut33c xerlinku Gannra x3Ann h x3t nx tooz tanaag. Haçbli apacc xeehunAeñ haçap yP Ayhr toohoxtryñ Gannra hp xetenged, Gannraçeh y3yyjut3 matepnari, mnñe caħħaraa aumniżżeek, aknit xepär GoħtoxAoo xahfarriżiñ akninnaAar hb „Cypratbi xeparruAxyhniñ haçap xypt33mkunñ hemmAlAyyiñx „ Garu haçbi AYHA soxnoñ GannrytarAçach yparAħħabir Garu B-Tyaratn xamtpañ soxnoñ Gannryiñx AYħa „Saxx appaġi Garu „uarrapgyiñax yparAħħabir uwyx3A xaparrAħħak Gannċa.



Page - 8


3apnm h̄t mapraah, ctp̄ec3ac xaparAaR.
xaparAaR, akn̄rtaatt, apn̄tluharac xaparAaR ba bary h̄t tooox yeeb trapAaR

График 9



Зарим нэмэлт ажил нь цаг хугацаа их зарцуулдаг ч тохируулан төоцөх ажилбар байдаггүй. Жишээ нь. Зочид хүлээн авах, баяр ёслолын үйл ажиллагаа зохион байгуулах зэрэг ажил байдаг . Үүнийг багц цагт яж тусгах, ямар кредит өлгох нь маргаан дагуулдаг.

График 10



Үнэхээр хөтөлбөр хийхдээ бүтээлчээр хийдэг эрэл судалгаа, үнэлгээний төлөвлөгөө, хэрэгсэл, аргаа боловсруулахад цаг хугацаа их шаардлагатай байдаг ч бусийн хэмжээнд батлагдсан төлөвлөгөө нэг ч байхгүй. Зөвлөмж санал дүгнэлт хийдэггүй. Мөн ээлжит хичээлийн төлөвлөгөөнд санал зөвлөмжийн хэсэйт багш тэмдэглэл хийдэггүй.

▷ Cyprartah xamparAcah GanAar

▷ Eepniree xerkyyjiax tenebneere

3opnyjiax Gantraci. VyA:

aktripli yhanix Ayrhax kypamatn xonooton "Barumni xerkun" A3retapnir Garu hapt
hapti xerkjini tarapax cyAartraa, Garu hapti Garu har tooox kypam, Garumni
A/214 tool tyuara "MEC-ph Garumni xerkun" xeteregep, mahan cypryjini Garu
saart, Mohrot yicbi XeAremepnii CanAph 2015 ophi 11 capbi 05-hpi eApnni
Ax saart, 19 Ayreep yhninii 19.1 Ayreep saart, 20 Ayrap yhninii 20.2.5, 20.2.8
M3aprekjini Gorobcpotpih tyxan xyhnni 18-p yhninii 18.1, 18.2, 18.3, 18.4

Aytyy xinciac Gorki ctpaccA3 3apar coper yP Ayh rapAar.
xahac hoy xinx xurxex3 m3Axxry, ymmap xinx ecton yhn33 xnh33 3c3n
Xinx aktaa h3rjhuk, toApopxon Gorrooyir33 Gorki n3m3 camrapAar.

3yhn33 A3 apayyjuk ypa tapah xinx.

rapracah tenebneehn Aray akntiix, meh eepnir Garu yP y33nry
ehAep GanAar. K3m33n3: Eepnir rapracah tenebneehn Aray gnu 6ycAph
Xinx ecton yhn33 xnh33 opohA xinx mapptiaray 3yhn33 ann xinx marapAar

Garu haptan xamtah "Barumni xerkun" A3retapnir raprax caha tpcch Gnt33.
hp Ayxan r3ek y33h Garu XAB3A-H Garu B.Tya, komnhetepnii Garu M.CahAar
hp xinciac yhn33 Tm3Aritx, Garutraakyyra, hototrookyyra, aktria xhx, Ayrhax
U33px cyAartraa, x3nayyj3rnih Apapa gn Garu hap eepnir xerkyyjiax xurx.

akntratrac xaparAar.

yA33c yP Ayh a xonogorAonry, xepal33 mapptiarayi akni xnh33 hp cyAartraa,
toApopxon goAnoro tenebneer xahratryir33 Garu hap Garu hara toooyjiax
Cypryjini ctpateri tenebneere, cypratbi aktrbi, Garu xerkyyjiax
Gorrox racah charayyApli A3bulyyjuk Ganach.

Vn akntratrac, tenebneere, GoAnotori y3nayyjiax eepnir yah xatah

5. Garu harni akntrajpih kni, ynpai capaa tyxan k3m33 cypartbi

umukyyjiax tooox

4. Akntrajpih toxnpooiyi 3apm aktripli 6ycA o3poutuo akntrajpih

3. Toooxok gyi arigah tyuara tuyaapra, yah xatah Ganx

2. Xinciac aktrbi yP Ayh, a xonogorAonp toooxok yhn33

1. Garu hap xinciac aktria GoAnoton myApapa y3nayyj3rnih AyC3A

- Ажлын байрны сургалт
- Боловсруулсан, баяжуулсан сургалтын хөтөлбөр
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, илтгэл
- Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн байдал
- Боловсруулсан ном сурах бичиг, гарын авлага, зөвлөмж
- Нийгмийн түншлэл-зохион байгуулсан ажил
- Олон нийтийн ажилд оролцсон байдал
- Оролцсон уралдаан тэмцээн
- Үнэлгээ/ажлын үнэлгээ/
- Тайлбар

“Багшийн хөгжил” дэвтэрийг хөтөлснөөр

- Багш өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөг өөрийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан төлөвлөгөөг боловсруулан төлөвлөнө.
- Багшийн өөрийн хөгжил нь сургуулийн хөгжилд шууд хамааралтай учир стратеги төлөвлөгөөний зорилго биелэнэ.
- Багшийн хувийн менежмент сайжирна.
- Өөрийн ажлыг хянахад тохиромжтой.
- Өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх шаардлага гарч ирнэ.
- Багшийн ажлыг үнэлэх, дэмжих үндэс болно.
- Сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд чухал нөлөө үзүүлнэ.

Мөн “M.Сандагсүрэнтэй хамтран багшийн ажлыг сараар төлөвлөх, түүний гүйцэтгэлийг бичиж тэмдэглэх, өөрийн хувийн болон цагийн менежментийг сайжруулан, хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтыг нэмэгдүүлэх, өөрийн ажлыг хянах, дүгнэж үнэлэхэд зорилгоор “Багшийн ажил үүргийн календарь” ийг багш нарт зориулан бэлтгэсэн.

Агуулга нь

- 2018 оны календарь
- Бүх багш нарыг төрсөн өдрөөр нь оруулж өгсөн
- Нүүрэнд нь тухайн багшийн зурагтай
- Тухайн сарын ажлын төлөвлөгөөг Steven Covey's time management matrix

загвараар хийсэн.

Үүнийг хөтөлснөөр

- ✖ Багшийн хувийн менежмент сайжирна.

- ✖ Өөрийн ажлыг хянаж дүгнэхэд тохиromжтой.
- ✖ Өөрийн нүдэнд харагдахуйц газар байрлуулна.
- ✖ Цаг ашиглалт сайжирна.
- ✖ Багаар ажиллах, хамт олонч хандлага төлөвшинө

Дүгнэлт

Багц журмыг хэрэгжүүлж байгаа аргачлал нь сургууль болгонд өөр байгаа бөгөөд багшийн хөгжлийг дэмжих гол хөшүүрэг бөгөөд сургуулийн стратеги төлөвлөгөө, тухайн хичээлийн зорилт, сургалтын үйл ажиллагаа, багшийн хөгжлийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөж бодитоор, шударга, уян хатан үнэлж дүгнэх шаардлагтай байгаа нь судалгаа, хэлэлцүүлэгийн зөвлөмжөөс харагдаж байгаа билээ.

Багш өөрийгөө хөгжүүлэх хамгийн чухал орчин бол сургууль буюу ажлын байр бөгөөд тэмдэглэл хөтөлж, төлөвлөгөө гаргах, түүний үр дүнг тогтмол тооцож байх нь багшийн хөгжих үндэс буюу эхлэл гэж үзсэнээр “Багшийн хөгжлийн дэвтэр” “Ажил үүргийн календарь” зайлшгүй тус нэмэр болох ба түүний ашиглалтыг сайжруулах нь багшийн өөрийн хөгжилд чухал ач холбогдолтой юм. Судалгаанаас манай сургуулийн багш нарын 40 хувь нь манлайлагчид байгаа тул багийн системийг үүрэг, багаар, , үр дүнтэй ажиллах сэдэл тэмүүлэлийг бий болгон багш нарыг хамтарч ажлаа төлөвлөх, гүйцэтгэх, мэдээлэл солилцох, туршлагаа хуваалцах, ЗАН, багаараа хамтран ажиллах нөхцөл боломж гаргаж өгөх зэрэг бүтээлч ажлууд явуулах, үр дүнг нь тооцох, хянах, урамшуулах шаардлагатай байна.

Ном зүй

1. Багц цаг тооцох журам
2. Ичинхорлоо „Сурган хүмүүжүүлэх арга,, УБ 2002 он
3. MCYT-ийн удирдлага, Багш наарт зориулсан мэргэжлийн боловсрол сургалтын талаар хууль тогтоомжийн эмхтгэл УБ 2010 он
- 4.” Удирдлагын ёс зүй “илтгэл 3.Энхгэрэл
5. Интернетээс авсан илтгэлүүд
7. „,Багшийн хөгжил, ур чадварыг үнэлэх арга зүй „ Д.Лхагвасүрэн
8. Хүний нөөцийн судалгаа
9. Бүрэн дунд боловсролын ахлах ангийн цөм хөтөлбөр
10. Мэргэжлийн боловсролын сургуулиудын багшийн хөгжлийн хөтөлбөр

/2016-2020он/

